



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20.14 оны 12 сарын 13-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнийг түр томилох тухай

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн Т.Одмаа өөрийн хүсэлтээр ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдсөн тул Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5-д заасны дагуу нөхөн сонгууль хүртэл орлох хүнийг түр томилох асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Говь хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

Нэг. Зуунай овогтой Шагдарсүрэн /РД:ХВ77021376/-г 2017 оны 12 сарын 13-ны өдрөөс эхлэн 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүнийг сонгох хүртэлх хугацаанд Говь хувьцаат компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр томилсугай.

Хоёр. Шинээр томилогдсон ТУЗ-ийн гишүүнд Компанийн тухай хууль болон холбогдох хууль журмын дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүний үүргээ хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болгосугай.

ТУЗ-ийн ДАРГА:

ТУЗ-ийн ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

Ц.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Ж.ОЮУНЧИМЭГ

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20... оны 12 сарын 13-ны өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

**ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай**

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбоотойгоор ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1, 81.2 заалтыг үндэслэн Говь хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг хавсралт-1 ёсоор шинэчлэн баталсугай.

Хоёр. Шинээр томилогдсон хороодын дарга болон гишүүдэд Компанийн тухай хууль, Говь ХК-ийн дүрэм болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүрмүүдэд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор өмнөх хороодын бүрэлдэхүүний ажил үүргийг дуусгавар болсонд тооцсугай.

ТУЗ-ийн ДАРГА:

Д.ГЭРЭЛМАА

ТУЗ-ийн ГИШҮҮД:

Ц.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Ж.ОЮУНЧИМЭГ

ТАКЭШИ КАМБЭ

З.ШАГДАРСҮРЭН

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН





Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2017 оны 12 сарын 13 -ний өдрийн хурлын
28-р тогтоолын 1 дүгээр хавсралт

ГОВЬ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮН

Хороодын нэр	Одоогийн бүрэлдэхүүн	
	Албан үүрэг	Овог, нэр
Нэр дэвшүүлэх хороо	дарга	М.Баяр
	гишүүн	Ц.Баатарсайхан
	гишүүн	Д.Гэрэлмаа
Цалин урамшууллын хороо	дарга	Д.Гэрэлмаа
	гишүүн	Ж.Оюунчимэг
	гишүүн	Такэши Камбэ
Эрсдэл, аудитын хороо	дарга	Б.Нандин-Эрдэнэ
	гишүүн	З.Шагдарсүрэн
	гишүүн	Д.Хулан



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20¹⁷ оны ¹² сарын ¹³ ны өдөр

Дугаар ³⁰

Улаанбаатар хот

Ногдол ашиг тараах хэлбэрийг өөрчлөх тухай

Говь ХК-ийн 2016 оны цэвэр ашгаас зарласан ногдол ашгийг тараах хэлбэрийг өөрчлөх тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны 02 сарын 10-ны өдрийн №2 тогтоолоор 2016 оны цэвэр ашгаас зарласан ногдол ашгийг компани дээрээ тарааж, хувьцаа эзэмшигчдэд хүссэн үед нь бэлэн мөнгөөр эсвэл харилцах дансанд нь шилжүүлэх арга хэлбэрээр олгохоор тогтоосныг хүчингүй болгосугай.

Хоёр. Говь ХК-ийн 2016 оны цэвэр ашгаас зарласан ногдол ашгийн үлдэгдэл тооцоог гарган, 2017 оны 12 сарын 28-ны өдрийн дотор Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд шилжүүлэхийг Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан-д даалгасугай.

Гурав. Ногдол ашиг тараахтай холбогдон гарах зардлыг холбогдох зардлын төсвөөс гаргахыг Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Ногдол ашгийг Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөр зуучлуулан тараахаар шийдвэрлэсэн тухай мэдээллийг зохих журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ-д даалгасугай.

ТУЗ-ийн ДАРГА:

Д.ГЭРЭЛМАА

ТУЗ-ийн ГИШҮҮД:

Ц.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Ж.ОЮУНЧИМЭГ

З.ШАГДАРСҮРЭН

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН

